



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 4/56

Есөнбулаг

Үнэлгээний хороо байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, 50.1.2 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам” А/254 дүгээр тушаалын хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 15.6 км зам тавих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:	Х.Баатарзориг	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
Гишүүд:	З.Жаргалтуяа	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)
	Г.Ууганбаатар	(Хөндлөнгийн төлөөлөл) (тохиролцсон)
Нарийн бичиг:	Ш.Соронзонболд	(Есөнбулаг сумын иргэн)
	Б.Эрхбаяр	(Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн)

2.Тендерийн баримт бичгийг боловсруулж, худалдан авах ажиллагааг хугацаа алдалгүй чанартай, шуурхай зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд танилцуулахыг үнэлгээний хороо (Х.Баатарзориг)-нд үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ

